Өмнөговь Аймгийн
ТӨВ НОМЫН САН

# ДЭЛХИЙН СОНГОДОГ ЗОХИОЛ

(БҮРТГЭН МЭДЭЭЛЭХ НОМ ЗҮЙ)

2021 ОН

# ӨМНӨХ ҮГ

Хүн төрөлхтөн өөрсдийн амьдрал, орчин тойрон, хүсэл мөрөөдлийн тухай анх хад чулуун дээр сийлэн зурж, улмаар бичиг үсэг бий болгож, уран яруу, утга гүнзгий үгээр илэрхийлсэн суут бүтээлүүдийг туурвиж, оюун билгийнхээ сан хөмрөгийг бүрдүүлэн баяжуулсан билээ. Олон зууны туршид бүтээгдсэн туульс, роман, тууж, эмгэнэлт болон инээдэмт зохиол, уран зөгнөл, яруу найраг зэргийн бүтээлүүдийн дээж сор нь он цагийн шалгуурыг давж, дэлхий дахинаа сонгодог утга зохиол хэмээн нэгэнт хүлээн зөвшөөрөгджээ.

# ДЭЛХИЙН СОНГОДОГ ЗОХИОЛ




Бурхан багшийн сургаал: 1 боть / Орч. Н.Энхбаяр.- УБ.: Монсудар, 2009.- 200х.- ISBN 978-99929-0-715-0.

***Агуулга:*** Будда хэмээх нь “гэгээрэлд хүрсэн” гэсэн утгатай самгарьд үг бөгөөд монголчуудын бурхан багш гэж өргөмжлөн нэрийдсээр иржээ. Тэрээр мах цусанд төрсөн хүн бүрийн гэгээрэлд хүрэх боломжтойг нээж, анх түрүүн гэгээрлийнхээ онолыг боловсруулж насан нөхчих хүртлээ энэ сургаалаа номлосон байна.




Хуучин гэрээ: 2 боть УБ.: МонСудар, 2009.-294х.- ISBN 978-99929-0-716-9.

***Агуулга:*** Дэлхийн тэр тусмаа Өрнийн соёл-иргэншил, утга зохиолын сэтгэлгээг ойлгоход түлхүүр болдог цорын ганц хөлгөн судар бий. Тэр бол “Хуучин гэрээ” юм. Хүн төрлөхтөний түүхэнд бүтээгдсэн хамгийн эртний номуудын нэг нь энэ билээ.




Эсхил ба бус.

Эртний герегийн жужгүүд: 3 боть / Эсхил, Софокл, Аристофан.- УБ.: МонСудар, 2009.-230х.- ISBN 978-99929-0-761-4.

***Агуулга:*** Эртний Герегийн театргүйгээр дэлхийн жүжгийн зохиолын хөгжлийг тодорхойлох аргагүй юм. Энэ бодит Герегийн театрын Алтан үеийн аугаа их гурван зохиолыг толилуулж байна. Эсхил “Цовдлуулсан Прометей”, Софокл “Эдип хаан”, Аритофан “Лисистрата.




Шармаа В.
Панчатантра: Таван сургамж: 4 боть / Орч. Ж.Гэндэндарам.- УБ.: МонСудар, 2009.- 320х.- ISBN 978-99929-0-753-3.

***Агуулга:*** Энэ зохиолын нэгэн өвөрмөц тал нь ихэнх баатруудаа адгуус дүрээр авсан боловч чухамдаа хүн ба хүний орчлонг дүрслэн
үзүүлсэн байдаг. Энэхүү зохиол таван үндсэн санаагаар сэдэв авч гэр ахуйн ёс суртахууныг тал талаас нь тайлбарлан сургаж өгсөн.




Бхагавата-Гийта: 5 боть / Орч. Ж.Гэндэндарам.- УБ.: Мон Судар, 2009.- 320х.- ISBN 978-99929-0-713-4.

***Агуулга:*** Эртний Энэтхэгийн алдарт “Махабхарата” туульсын нэгээхэн хэсэг, санскрит хэлээр бичигдсэн яруу найргийн энэхүү бүтээл Ведийн ёсны чухал дурсгал бөгөөд орчин цагийн уншигдад зориулан тайлбарласан хувьилбар юм.




Коран: 6 боть / Орч. Ц.Гомбосүрэн.- УБ.: Мон Судар, 2009.- 384х.- ISBN 978-99929-0-717-7.

***Агуулга:*** Коран нь Аллахаас өөр бурхан эзэн гэж үгүйг номлосон нэгэн үзүүрт утгыг илтгэх авч үнэхээр уран тансаг, дүрслэл, зураглал сайтай, яруу найргийн хэлээр бичигдсэн байдаг.




Үлгэрийн далай: 7 боть / Орч. Д.Бүрнээ, Д.Энхтөр.- УБ.: Мон Судар, 2009.- 280х.- ISBN 978-99929-0-746-0.
***Агуулга:*** Сайн хийгээд муу, цэцэн хийгээд тэнэгийг ялгагч гэсэн утга бүхий, анх самгарьд хэлээр бичигдсэн, төвдөөр "Занлүн" хэмээгддэг эл судрыг өвөг дээдэс маань ам дамжуулан ярьдаг, ардын үлгэрчид нэг бүрчлэн мэддэг байсан эдгээ үлгэрийн гайхамшигт далайд сэлэн умбахдаа та бурханлиг оюун санааны бишрэлт ертөнцийг олж харах болно.




Мянга нэгэн шөнийн үлгэр: 8 боть / Орч. С.Бадраа.- УБ.: Мон Судар, 2008.- 296х.- ISBN 978-99929-0-523-9.
***Агуулга:*** "Мянга нэгэн шөнийн үлгэр-ийн уг үндэс юу билээ? Хаашаа ч эргэж болзошгүй үйл явдалуудын эргүүлэг, нэг бол маш их жаргалтай, эсвэл тэсвэрлэшгүй зовлонтой, нэг бол хэмжээлшгүй баян, эсвэл ор хоосон ядуу хүмүүс. Бас юу хийж байгаагаа хэнд тайлагнадаггүй хаадын ертөнц. Эгээ л бурхад шиг хязгааргүй эрх мэдлэгтэй атлаа хариуцлага хүлээдэггүй тийм хаад....




Шикибу М.
Гэнжийн туульс: 9 боть / Орч.О.Жаргалсайхан.- УБ.: Мон Судар, 2009.-224.- ISBN 978-99929-0-748-7.
***Агуулга:*** "Гэнжийн туульс" бол хүн төрлөхтний утга зохиолын түүхэн дэх анхны роман юм. Гэнжи хэмээх нэгэн Хунтайжийн амьдралаар дамжуулан хайр дурлал, хүн ёсны утга учрын тухай өргөн дэлгэр өгүүлжээ.

# ДЭЛХИЙН СОНГОДОГ ЗОХИОЛ




Монголын нууц товчоо: 10 боть / Орч. Ц.Дамдинсүрэн.- УБ.: Мон Судар, 2009.- 192х.- ISBN 978-99929-0-729-0.
***Агуулга:*** Монголын түүхийн хосгүй баримт болохоос гадна нүүдэлчдийн оюуны сэтгэлгээний дээд түвшний бүхий л ололтыг дуртгасанаараа орчин цагийэ утга зохиол судлалд жишиг болохуйц туурвил билээ.




Боккаччо Ж.
Декамерон хэмэх бичиг: 11 боть / Орч. Ж.Цэвээн, А.Дашням.- УБ.: Мон Судар, 2009.- 168х.- ISBN 978-99929-0-689-8.
***Агуулга:*** Сэргэн мандалтыг үеийн энэхүү гайхалтай чөлөөт сэтгэлгээний дууллыг хуучинсаг үзэлтнүүд сүм хийдийнхний зүгээс олон зуун жилийн турш хориотой номын жагсаалтад бүртгэж, хар дансалсан юм. Энэ бүтээлээрээ зохиолч "Эротик уран зохиолын хаан" хэмээн дэлхий дахинаа өргөмлөгджээ.




Раблэ Ф.
Гаргатюа ба Пантагрюэль 12 боть / Орч. С.Сандагдорж.- УБ.: Мон Судар, 2008.- 192х.- ISBN 978-99929-0-691-X.
***Агуулга:*** "Гаргатюа ба Пантагрюэль" романд гарч буй нийтээрээ зугаалж цэнгэн, наргин байгаа орчин нь дундад эртний хүний хувьд өөрийгөө илэрхийлэх бараг л цорын ганц нөхцөл юм. " Тэнэгүүдийн найр" "Годил толгойтнуудын зугаа цэнгэл", эх адаггүй алиа марзан хаширгалдаан бол тэр үед ах захаа алдсан зүйл огт биш, уламжлалт зан үйл байв...

## ДЭЛХИЙН СОНГОДОГ ЗОХИОЛ




Шэкспир У.

Эмгэнэлт жүжгүүд: 13 боть.- УБ.: Мон Судар, 2009.- 552х.- ISBN 978-99929-0-777-0.

***Агуулга:*** Ромео Жульета хоёр, Хамлет, Отелло, Лир ван, Макбет жүжгүүд.




Монтэнь М.

Сонгомол эссэнүүд: 14 боть / Орч. Г.Аюурзана.- УБ.: МонСудар, 2009.- 240х.- ISBN 978-99929-0-775-4.

***Агуулга:*** Сэргэн мандалтын үеийн Францийн философи Мишель Эйкэм дө Монтэнь орчин цагийн эссэ хэмээх уран зохиолын төрөл зүйлийг үндэслэгч юм. Анхандаа гүн ухааны болон уран зохиолын бүтээлүүдийг задлан тайлбарлаж, өөрийн санаагаар баяжуулах аястай байсан түүний тэмдэглэлүүд яваандаа сэтгэлгээний хувьд задарч, уран сайхны өндөр үнэ цэнэтэй, гойдын уран бичлэгтэй бүтээл болжээ.




Чэнь Энь

Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл: 15 боть / Орч, Арана, С.Хөвсгөл.- УБ.: Мон Судар, 2009.- 608х.- ISBN 978-99929-0-754-1.

***Агуулга:*** Романы үндсэн санаа нь хүний мөн чанар энэ хорвоод эзлэх түүний байр суурь, үнэний эрэл ба танин мэдэхүй, буян нүглийн тэмцлийн сэдэв дээр зангидсан болно.

# ДЭЛХИЙН СОНГОДОГ ЗОХИОЛ




Сервантес М.

Кихот ноён: 16 боть / Орч. Т.Жамбал.- УБ.: Мон Судар, 2009.- 496.- ISBN 978-99929-0-745-2.

***Агуулга***:..Дон Кихот бол шударга бус явдалыг үгүй хийхийг эрмэлзэгч билээ..., .. “Кихот ноён” зохиол нь харгис араншингийн ил тод нэвтэрхий толь юм..., Хэдийгээр амьдралын уйтгартай бодит зарчимд бууж өгч, улмаар Христийн ёс жаягт захирагдан төрөл арилжиж буй хэдий ч, Дон кихот бол хорвоо дээрх хамгийн ухаалаг мэргэх хүн билээ.




Алтан бумбан дахь лишийн цэцэг: 17 боть / Орч. Б.Дашцэрэн.- УБ.: МонСудар, 2009.- 800х.- ISBN 978-99929-0-769-7.

***Агуулга:*** Эротик утга зохиолын оргил хэмээн алдаршсан хятадын сонгодог роман.




Дефо Д.

Робинзон Крузо: 18 боть / Орч. Э.Оюун.- УБ.: МонСудар, 2009.- 208х.- ISBN 978-99929-0-732-0.

***Агуулга:*** Робинзон хэмээх нэр иргэншлээс тусгаарлагдаад хүний төрөлх мөн чанараа хадгалан, өөрийн гараар амьдралаа бүтэн авч үлдэгсдийн бэлгэдэл дүр болсонд энэ романы гоц үнэ цэнэ оршдог.

# ДЭЛХИЙН СОНГОДОГ ЗОХИОЛ




Свифт Ж.

Гулливерийн аялал: 19 Боть / Орч. Ц.Шүгэр.- УБ.: Мон Судар, 2009.- 136х.- ISBN 978-99929-0-240-X.

***Агуулга:*** “Гулливерийн аялал”-ын хамгийн гол утга учир нь нийгэм дэх ялзрал, мунхаглалыг тохуурхан шоолж, ултай шүүмжилсэнд оршино. Гулливер хэмээх зохиомол баатар, орой болоод аварга хүмүүсийн уран сэтгэмжит дүрээр дамжуулан мунхагийн харанхуйг элэглэсэн уг бүтээлээс жинхэнэ уран зохиол ямаршуу далд гүн утгатай, гүн санааг ямархан энгийн урнаар иллэрхийлдэгийн жишээг харж болно.




Вольтер Ф., Дидро Д.

Жамаараа яваа ертөнц: 20 боть / Орч. Т.Төмөрхүлэг.- УБ.: Мон Судар, 2009.- 336х.- ISBN 978-99929-0-389-9.

***Агуулга:*** философийн роман хэмээх төрөл жанр доороо үнэхээр онцгой энэ бүтээлийн гол баатар, сэтгэгч Панглос шиг хошин наргиантай дүр манай ч, дэлхийн ч уран зохиолд ховор....




Эрт эдүгээхийн гайхамшиг сайхан үзэгдэл: 21 боть: Дээд дэвтэр / Ред. Ш.Чоймаа, М.Баярсайхан.- УБ.: МонСудар, 2009.- 424х.- ISBN 978-99929-0-810-6.

***Агуулга:*** хятадын эртний аман үлгэрээс уламжилсан энэ бүтээл 17-р зууны эхэн хагаст зохиогдсон ажээ. Чухамдаа өгүүллэгийн эмхэтгэл хэмээн нэрлэж болмоор...




Эрт эдүгээхийн гайхамшиг сайхан үзэгдэл 22 боть: Доод дэвтэр / Ред. Ш.Чоймаа, М.Баярсайхан.- УБ.: МонСудар, 2009.- 448х.- ISBN 978-99929-0-824-6.

***Агуулга:*** хятадын эртний аман үлгэрээс уламжилсан энэ бүтээл 17-р зууны эхэн хагаст зохиогдсон ажээ. Чухамдаа өгүүллэгийн эмхэтгэл хэмээн нэрлэж болмоор...




Цао Сюэ Чинь

Улаан асрын зүүд: 23 боть / Орч. Хасбуу, С.Хөвсгөл ба бус.- УБ.: Мон Судар, 2009.- 528х.- ISBN 978-99929-0-728-2.

***Агуулга:*** Манж Чин улсын үеийн язгууртан гэр бүлийн амьдралаар дамжуулан, Хятадын нийгмийн харилцаа, хувь хүний дотоод ертөнцийн сэдвийг гойд урнаар илэрхийлсэн энэ бүтээл нь дэлхийн уран зохиол дахь хайр дурлалын сэдэвт хамгийн шилдэг романы нэгд зүй ёсоор тооцогддог.




Гёте И.В.

Фауст Эмгэнэлт жүжиг: 24 боть / Орч. С.Батбилэг.- УБ.: Мон Судар, 2009.- 326.- ISBN 978-99929-0-805-Х.

***Агуулга:*** Энэ жүжиг нь хэдийгээр эмгэнэлт злохиол гэж тооцогддог ч хошин зохиолын элемент ч биз бишгүй бий. Гол баатар нь бүхнийг танин мэдэх гэгээрэлдээ хөтлөгдөн, муу муухайн хүчнүүдтэй сөргөлдөж, эцэст нь бурханлиг ариун бүхний үнэ цэнийг таньж үүрдийн авралд хүрч байгааг харуулжээ.




Бальзак О.

Эцэг Горио: 25 боть / Орч. Д.Батсүх, Т.Пүрэвжал.- УБ.: Мон Судар, 2009.- 288х.- ISBN 978-99929-0-763-0.

***Агуулга:*** Дүр бүрээ маш нарийн зурж тодорхойлон баатруудынхаа сэтгэлзүйн дотоод ээдрээг гайхалтай үзүүлсэн мөнхийн зохиол дотор энд толилуулж буй "Эцэг Горио" "Гобсек" тууж онцгой байр эзэлнэ. Эдгээр зохиолын үндсэн сэдэв нь мөнгөний сүйрүүлэгч уршиг, хүний ёс зүйн доройтол, мунхаглал билээ.




Хюго В.

Парисийн эх дагинийн сүм: 26 боть / Орч. Б.Пүрэвбаатар.- УБ.: МонСудар, 2009.- 480х.- ISBN 978-99929-0-776-2.

***Агуулга***: Романд гарч буй түүхэн үйл явкдэл үнэхээр л болсон явдалыг хөндсөн ч зохиолмол дүрүүд болох гудамжны бүжигч хийсэн Эсмеральда, сүмийн хамба Клод Фролло, түүний боол Квазимодо, шүлэгч Грэнгуар нарын зөрчилт амьдрал....Дүрүүдийн зөрчил, ялгарлыг Хюго бараг л зураач хүн шиг нарийн гэрэл сүүдэр хослуулан зохиомжилжээ.




Диккенс Ч.

Дэвид Копперфилд: 27 боть / Орч. Ш.Очирбат.- УБ.: МонСудар, 2009.- 750х.- ISBN 978-99929-0-762-2.

***Агуулга:*** Зохиолчийн бага насандаа туулж өнгөрүүлсэн хэцүү амьдралын дүр зураг харагддаг.




Голь Н.В.

Петербургийн туужис: 28 боть / Орч. Б.Пүрэвбаатар.- УБ.: МонСудар, 2009.- 208х.- ISBN 978-99929-0-714-2.

***Агуулга:*** Украны хөдөө нутагт төрж өссөн зохиолч Петербургт суурьшсаныхаа дараа их хотын амьдралыг хоржоонтой егөөч маягаар дүрсэлсэн нт Невийн өргөн чөлөө, Хамар, Хөрөг зураг, Шинель, Галзуу хүний өдрийн тэмдэглэл туужуудад харагдана.




По Э.А

Улаан үхлийн баг: 29 боть / Орч. Б.Одгэрэл.- УБ.: Мон Судар, 2009.- 184х.- ISBN 978-99929-0-804-1.

***Агуулга:*** Эдгар Аллан По нь богино өгүүллэгийн мастер детектив зохиолын эцэг билээ. Түүний Вильям Вильсон, Ашерын гэрийн мөхөл, Торх амонтильадо дарс, Овгос дэвхэс, Лонкноос олдсон бичиг, Улаан үхлийн баг зэрэг өгүүлэг нь багтжээ.




Флобер Г.

Бовари хатагтай: 30 боть / Орч. Ж.Намсрай.- УБ.: МонСудар, 2009.- 296х.- ISBN 978-99929-0-731-2.

***Агуулга:*** Хөдөөгийн эмчийн гэргий тосгоны амьдралын уйтгарт хоосноос зугтахыг эрмэлзсэн Эмма Боварийн дурлалын түүхээр дамжуулж хүний сэтгэлийн нарийн чанад руу өнгийсөн энэ роман 19-20 зууны уран зохиолд нээлт болжээ.




Толстой Л.Н.

Анна Каренина: 31 боть / Орч. Ш.Очирбат.- УБ.: МонСудар, 2009.- 784х.- ISBN 978-99929-0-608-1.

***Агуулга:*** Гэр бүлийн тэр дундаа эмэгтэй хүний сэтгэл зүйн тухай роман билээ. “Ойлгоно гэдэг бол өршөөх уучлахын нэр” хэмээх сонгодог хэлцийг Толстой өөрийнхөө баатарт үнэн сэтгэлээсээ хайртай ч өршөөхийг хүсээгүй дотоод ертөнцөөс шүүх эрхийг л ганц олсоноор тэр хайраа хязгаарласан нь бүтэц хийгээд сэтгэцийн онцгой зөрчил болжээ.




Достоевкий Ф.М.

Карамазовын хөвүүд 32 боть / Орч. Ц.Гомбосүрэн.- УБ.: МонСудар, 2009.- 760х.- ISBN 978-99929-0-727-4

***Агуулга:*** Карамазовын хөвүүд бол Достоевский бусад романуудад байнга давтагдсаар ирсэн адал явдалт зохиолын гайхамшигт жишээ билээ. Сонирхол татмаар өгүүлэмж олон өчүүхэн жижиг хэсэг, яльгүй өгүүлэмжээр ч уншигчдыг өдөн дуудаж, сониуч занг бадраана. Бүлгүүдийн энр л гэхэд этгээд содон... Уг ном нь адал явдал, чамбай бодож сүлжилдүүлсэн гэмт хэргийн роман бөгөөд харин үйл явдлын өрнөл нь их удаан.

# ДЭЛХИЙН СОНГОДОГ ЗОХИОЛ




Твен М.

Хаклбэрри Финнд тохиолдсон адал явдал 33 боть / Орч Г.Төмөрбат.- УБ.: МонСудар, 2009.- 256х.- ISBN 978-99929-0-725-8

***Агуулга***: Самкэл Ланхорн Клэмэнс хэмээх залуу Америк орноор хөндлөн гулд хэрэн тэнэж сүүлдээ Миссисипи мөрнөөр аялах хөлөг онгоцны залуурч болжээ. Ийн явж амьдралыг таньсан сэтгэлдлээрээ зохиол бичиж үзэхээр шийдэж Марк твен буюу “Хос тэмдэг” хэмээх нууц нэр сонгосон байна.




Чехов А.П.

Цахлай: 34 боть.- УБ.: МонСудар, 2009.- 216х.- ISBN 978-99929-0-755-X.

***Агуулга:*** Энэ бүтээлд Зохиолчийн Түшмэлийн үхэл, Бүдүүн нарийн хоёр, Хамелеон, Загасны дурлал таил эр, найрал дуучин хүүхэн, хожлын тасалбар зэрэг 16 өгүүллэг, цахлай жүжиг багтжээ.




Дэлхийн шилдэг үлгэрүүд: 35 боть / Эмхт. З.Түмэнжаргал.- УБ.: МонСудар, 2009.- 208х.- ISBN 978-99929-0-797-5.

***Агуулга:*** Үлгэр бол хүүхдийн зохиол гэж зарим хүн эндүү боддог. Оюун санаа нь балчир хэвээрээ яваа хүнд ихэнх буурьтай бүтээлүүд хүүхдийн зохиол шиг санагддагийн адил, үлгэр бол буурьтай утга зохиол билээ. Үлгэр яаж төгсчихөв өө гэдгийг ултай мэдэж авахын тулд аль багаасаа мэддэг үлгэрүүдээ ч ахиад нэг унших хэрэгтэй. Ер нь номыг дахин уншина гэдэг нь амт шимтийг нь мэдэх шалгарсан арга билээ.




Хашек Я.
Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал: 36 боть / Орч. Ш.Очирбат.- УБ.: МонСудар, 2009.- 632х.- ISBN 978-99929-0-730-4.
***Агуулга:*** Түүний баатар Иззеф Швейкийг цайлган мангуу, зальжин сүйхээтэн алин болохыг эцэслэн дүгнэхэд хэцүү. Ердийн амьдралд жигтэйхэн зохицсон гүйлгээ хар ухаантай атлаа төр засагт хамаатай яриа өрнөхөөр л засрашгүй мунхаг болчихдог Швейк бол яг л хамелеон шиг уг романыг хэн яаж харахыг хүснэ түүнд нь хувилж чаддаг ид шидтэй дүр юм.




Кафка Ф.
Шүүх: 37 боть / Орч. Ц.Сүхбаатар.- УБ.: МонСудар, 2009.- 288х.- ISBN 978-99929-0-077-6.
***Агуулга:***. “Кафкагийн” хэмээх тусгай нэр томьёо утга зохиолын хэлэнд бий болж, хувь хүний өөрийн хянаж чадах хэр хэмжээнээс хэтийдсэн хүчний өмнө золиос болж буй аймшигт харгис дарангуйллын нэрийтгэл болон төлөвшсөн юм. Түүний хамгийн алдартай тууж “Хувирал”, хамгийн алдартай роман “Шүүх” хоёрыг энэ номонд нэгтгэн хэвлэжээ.




Рюноскэ А.
Ид шидийн урлаг: 38 боть / Орч. Д.Цоодол.- УБ.: МонСудар, 2009.- 224х.- ISBN 978-99929-0-726-6.
***Агуулга:*** Акутагава Рюносхэ бол японы уран зохиолд сэтгэлзүйн гүнзий зөрчилт өнгө аясыг авчирсан, дорно дахины уламжлалт бичлэгийг өрнийн уур амьгалаар шинэчилж сэлбэсэн хүн юм. Энэхүү номд түүний Хамар, Ойд болсон явдал, Мори

багш, Рашёомон хаалга, Ид шидийн урлаг, Санэмоны гэмт явдал зэрэг өгүүллэг, зураглал, ярилцлага багтжээ.




Фолкнер У.

Буугаад ирээч, Мосе!: Метароман: 39 боть.- УБ.: МонСудар, 2009.- 254х.- ISBN 978-99929-0-806-8.

***Агуулга:*** “Буугаад ирээч, Мосе!” хэмээх ном бол орчин үеийн уран зохиол дахь метроманы эхлэл болёон бүтээл юм. Энэхүү номын цөс болсон “Баавгай” тууж бол XX зууны хүүрнэл зохиолын нэгээхэн гайхамшиг юм. Түүний 7 зохиол нь энэ номонд орсон байна.




Хэмингуэй Э.

Зэр зэвсэг минь баяртай: 40 боть / Орч. М.Цэдэндорж, Б.Одгэрэл ба бус.- УБ.: МонСудар, 2009.- 384х.- ISBN 978-99929-0-041-5.

***Агуулга:*** Зохиолчийн залуу насандаа бичсэн хамгийн шилдэг ромэн нь “Зэр зэвсэг минь баяртай” билээ. Уянгын сэдэвт богино өгүүллэгүүд нь өнөө хэр дэлхийн бүх хэл дээрх антологуудыг чимсээр байгаа. Энэ номд түүний роман, өгүүллэг, тууж багтсан байгаа.




Борхэс Х.Л.

Хоёр хаан, хоёр хонгил: Шилмэл өгүүллэгүүд: 41 боть / Орч. Г.Аюурзана.- УБ.: МонСудар, 2009.- 160х.- ISBN 978-99929-0-838-6.

***Агуулга:*** Насан туршдаа гагцхүү шүлэг, өгүүллэг, эссэ бичсэн энэ зохилчийн нэр өнөөгийн утга зохиолд ямар ч том романаас илүү мөнхрөн үлдсэн юм. Түүний шилмэл өгүүллэгийг толилуулж байна.




Булгаков М.А.

Мастер Маргарита хоёр: 42 боть / Орч. Ц.Гомбосүрэн.- УБ.: МонСудар, 2009.- 384х.- ISBN 978-99929-0-744-4.

***<u>Агуулга:</u>*** Момква хотод буг чөтгөр жинхэнээрээ айлчлан ирсэн тухай этгээд сонин щүйл явдлыг өгүүлдэг энэ роман хориотой байхаас ч аргагүй. Эмч мэргэжилтэй Булгаков эмчилгээний журмаар олгогддог асан хар тамхинаасаа амьдралын хүнд нөхцлийн эрхээр хэрэглээд занщсан байж л дээ. Тиймээс шидэт реализмын хамгийн чухал бүтээлүүдийн нэгд тооцогддог энэ роман мансуурлын нөлөөн дор бичигдсэн гэж шинжээчид үздэг.




Сартр Ж.П.

Үг: 43 боть / Орч. Г.Аюурзана.- УБ.: МонСудар, 2009.- 176х.- ISBN 978-99929-0-822-Х.

***<u>Агуулга:</u>*** Монгол хэлнээ анх удаа хэвлэгдэж байгаа "Үг" тууж нь зохиолч хүний ертөнцийн төлөвшил, үгийн урлагийн мөн чанарын тухай хамгийн гоц туурвил хэмээгддэг бөгөөд Жан Поль Сартр энэ зохиолоороо 1964 онд Нобелийн шагнал хүртсэн байна.




Оруэлл Ж.

Мянга есөн зуун наян дөрөв: 44 боть / Орч. Д.Чулуундорж.- УБ.: МонСудар, 2009.- 256х.- ISBN 978-99929-0-460-7.

***<u>Агуулга</u>***: 1984 онд хар дарсан зүүд мэт айдас хүйдэс ноёлсон,бүхнийг эрхшээгч цагдаагийн улс дэлхийг эрхшээж буй тухай энэ зөгнөлт романаа 1948 онд бичжээ. Тэрээр энэ романаараа тоталитар нийгмийн тогтолцоог үзэл

санааны хувьд нэг мөсөн булшилсан юм. ... Хуулиар зөвшөөрөөгүй үйл бодлоо гээд хамаагүй хүнд дурлалаа гээд цагдаа нар баривчилбал та яах вэ?




Камю А.

Этгээд хүн: 45 боть / Орч. Т.Төмөрхүлэг.- УБ.: МонСудар, 2009.- 120х.- ISBN 978-99929-0-690-1.

***Агуулга:*** Эхлээд жирийн албан хаагч, Алжир хотын иргэн Марсо хэмээгч залуугийн өдөр тутмын нэг хэвийн амьдрал гардаг. Эх нь нас барж түүнийгээ оршуулдаг. Мерсо бичээчийн ажилтай Мари гэгч залуу бүсгүйтэй холбогддог... Ийм гаригт өглөө сэрэнгүүтээ орноосоо босдоггүй, талхандаа явахаас залхуурдаг, шарсан өндөгөө хайруулын тавагнаас нь иддэг, тамхи угсруулан татдаг ийм л хүн, түүнийг уйтгарладаг гэж хэлж болохгүй, цаг нөхцөөж ганц олдсон амьдралаа дэмий үрж байгаа хүн. Энийгээ ч ухамсарладаггүй....




Абсурт театр: 46 боть / Орч. Г.Аюурзана.- УБ.: МонСудар, 2009.- 336х.- ISBN 978-99929-0-798-3.

***Агуулга:*** Өнөөгийн ертөнцийн утга учиргүйг түүнчлэн орчин цагийн хүний ухамсрыг цогцоор нь илэрхийлэхэд тэр тусмаа тайзнаа үзүүлэхэд реализм хангалттай биш хэмээх үзэлээс нь А.Артогийн театр хийгээд “Абсурдизм” бий болсон юм.

# ДЭЛХИЙН СОНГОДОГ ЗОХИОЛ




Маркес Г.Г.

Зуун жилийн ганцаардал: 47 боть / Орч. Г.Аким.- УБ.: МонСудар, 2009.- 312х.- ISBN 978-99929-0-488-7.

***Агуулга:*** Махондо хэмээх зохиомол тосгоны болон уг тосгоныг үндэслэсэн, мөн тосгонтойгоо хамт сүйрч буй буэндиагийн гэр бүлийнхний түүх маягаар бичигдсэн энэ зохиолд бодит амьдрал, хийсвэрлэл үлгэр домгийн болоод уянгын, түүнчлэн эротик дүрслэлүүд улс төр нийгмийн бусармаг дүр зургуудтай чөлөөтэй бөгөөд урнаар сүлэлдэж сүлжилдсэн нь гайхалтай.




Юкио М.

Алтан асрын сум: 48 боть / Орч. Ц.Цэнгэл.- УБ.: МонСудар, 2009.- 192х.- ISBN 978-99929-0-712-6.

***Агуулга:*** Гайхалтай яруу найрагч, зэн-буддизмыг бишрэгч жүжигчин, найруулагч, хөгжимчин, кэндо, каратегийн мастер, байлдааны нисэх онгоцны чадварлаг нисэгч, долоон удаан дэлхийг тойрон аялсан энэ өвөрмөц хүний дотоод ертөнцийн бүхий л нууцыг энэ романаас олж нээж болно.




Коэльо П.

Алхимич: 49 боть / Орч. Л.Лхагвадулам.- УБ.: МонСудар, 2009.- 136х.- ISBN 978-99929-0-778-9.

***Агуулга:*** “Алхимич” бол зохиолчийн 2 дахь роман. Одоогоор дэлхийд хэвлэгдэж гарсан уран зохиолын номууд дотор 65 сая ширхэг борлогдсон тоогоор дээд амжилт тогтоогоод байна.




Дэлхийн яруу найргийн охь дээжис: 50 боть / Орч. Г.Аюурзана.- УБ.: МонСудар, 2009.- 392х.- ISBN 978-99929-0-779-7.

***Агуулга:*** Хүн төрлөхтний яруу найргийг туульсын ба уянгын хэмээн үндсэн хоёр хэсэгт хуваах бөгөөд уянгын яруу найргийн хөгжил олон тооны урсгал чиглэлийг бий болгодог. Энэ боть антологт нэн эрт үеэс эхлээд өнөөдрийг хүртэлх уянгын яруу найргийн хамгийн тод томруун, сонирхолтой төлөөлөгчдийг хамруулан, бүтээж туурвисан он цагаар нь дараалууллаа. Энд нийтдээ 130 гаруй яруу найрагчийн 280 гаруй шүлэг орсон.

## " НЭРИЙН ХЭЛХЭЭС "


### А

Аким ............................18
Арана ............................6
Аристофан ....................2
Аюурзана Г. 6, 15, 16,17, 19

### Б

Бадраа С........................4
Бальзак О ...................10
Батбилэг С....................9
Батсүх Д......................10
Баярсайхан М...........8, 9
Боккаччо Ж ...................5
Борхэс Х.Л ..................15
Булгаков М.А ..............16
Бүрнээ Д .......................4

### В

Вольтер Ф .....................8

### Г

Гёте И.В ........................9
Голь Н.В.......................11
Гомбосүрэн Ц ...3, 12, 16
Гэндэндарам Ж ............3

### Д

Дамдинсүрэн Ц ............ 5
Дашням А..................... 5
Дашцэрэн Б.................. 7
Дефо Д ......................... 7
Дидро Д ........................ 8
Диккенс Ч ................... 10
Достоевкий Ф.М ......... 12

### Ж

Жамбал Т..................... 7
Жаргалсайхан О .......... 4

### К

Камю А ....................... 17
Кафка ф ..................... 14
Коэльо П..................... 18

### Л

Лхагвадулам Л ........... 18

### М

Маркес Г..................... 18
Монтэнь М.................... 6

### Н

Намсрай Ж................. 11

**О**

Одгэрэл Б ............ 11, 15
Оруэлл Ж................... 16
Очирбат Ш...... 10, 12, 14
Оюун Э................... 7, 13

**П**

По Э.А ......................... 11
Пүрэвбаатар Б...... 10, 11
Пүрэвжал Т................ 10

**Р**

Раблэ Ф ....................... 5
Рюноскэ А.................. 14

**С**

Сандагдорж С.............. 5
Сартр Ж.П ................. 16
Свифт Ж ...................... 8
Сервантес М................ 7
Софокл ........................ 2
Сүхбаатар Ц .............. 14

**Т**

Твен М ....................... 13
Толстой Л.Н............... 12
Төмөрбат Г ................ 13
Төмөрхүлэг Т.......... 8, 17
Түмэнжаргал З .......... 13

**Ф**

Флобер Г ................... 11
Фолкнер У ................. 15

**Х**

Хасбуу ......................... 9
Хашек Я..................... 14
Хөвсгөл С ............... 6, 9
Хэмингуэй Э ............. 15
Хюго В ...................... 10

**Ц**

Цао Сюэ Чинь ............. 9
Цоодол Д.................. 14
Цэвээн Ж..................... 5
Цэдэндорж М ............ 15
Цэнгэл Ц.................. 18

**Ч**

Чехов А.П.................. 13
Чоймаа Ш ............... 8, 9
Чулуундорж Д ........... 16
Чэнь Энь ..................... 6

**Ш**

Шармаа В.................... 3
Шикибү М ................... 4
Шүгэр Ц...................... 8
Шэкспир У .................. 6

**Э**

Энхбаяр Н......................2
Энхтөр Д........................4
Эсхил .............................2

**Ю**

Юкио М....................... 18

Номын санч
Н.Даваажаргал

